



БАЯНХОНГОР АЙМАГ  
ЖАРГАЛАНТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2024 оны 12 сарын 06 өдөр

Дугаар А/108

Эмээлтөлгой

Мал, тэжээвэр амьтад, хашаа худгийн  
2024 оны тооллого явуулах тухай

Монгол Улсын "Статистикийн тухай" хуулийн 20 дугаар зүйлийн 20.1, 20.2 дахь заалт, Засгийн газрын 2003 оны "Тооллогын товыг өөрчлөн тогтоох тухай" 224 дүгээр тогтоолын 1.2, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалаар батлагдсан "Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам"-ын 2.1.5, аймгийн Засаг даргын 2024 оны 12 дугаар сарын 03-ны өдрийн А/663 дугаар захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Мал, тэжээвэр амьтад, хашаа, худгийн тооллогыг 2024 оны 12 дугаар сарын 07-17-ны өдрүүдэд сумын хэмжээнд зохион байгуулан явуулах комиссын бүрэлдэхүүнийг хавсралтаар баталсугай.

2. Бүх шатны Засаг дарга, Засаг даргын Тамгын газар болон нутгийн захиргааны бусад байгууллагын ажилтан, малчид, малтай иргэд, аж ахуйн нэгж, байгууллагуудад орон нутгийн эдийн засгийн голлох салбарын хувьд мал тэжээвэр амьтад, хашаа, худгийн тооллогын ажилд өндөр ач холбогдол өгч сум, багийн түвшинд бэлтгэл, зохион байгуулалтыг эртнээс сайтар хангуулж, мөрдөгдөж буй заавар журмын дагуу чанартай зохион байгуулж, мал бүрийг тооллогод бүрэн хамруулах, тооллогын ажилд оролцож байгаа төрийн албан хаагчдын хариуцлагыг өндөржүүлж, гарч буй зөрчил, дутагдлыг газар дээр нь залруулж, зөрчил гаргасан ажилтнуудад хариуцлага тооцон холбогдох арга хэмжээг авч ажиллахыг комиссын дарга (Б.Түмэнжаргал)-д үүрэг болгосугай.

3. Мал, тэжээвэр амьтад, хашаа, худгийн тооллогын маягтыг цахим программаар шивэхтэй холбогдуулан бэлтгэл ажилд онцгой анхаарч, дүн мэдээллийг мал тооллогын нэгдсэн санд оруулж 2024 оны 12 дугаар сарын 25-ны дотор аймгийн Статистикийн хэлтэст хүлээлгэн өгөхийг багийн Засаг дарга нар болон Төсөв, төрийн сангийн мэргэжилтэн (Н.Эрдэнэ-Очир) нарт даалгасугай.

4. Үндэсний Статистикийн хорооноос мал, тэжээвэр амьтад, хашаа, худгийн тооллогын чанар, бодит байдлыг сайжруулах, тоологд орчин үеийн шинэ техник, технологи ашиглах боломжийг судлах, мэдээллийн видео сан үүсгэх чиглэлээр малыг цувуулан тоолж буй видео бичлэгийг заавар чиглэлийг баримтлан, чанартай хийж 12 дугаар сарын 20-ны дотор аймгийн Статистикийн хэлтэст хүлээлгэн өгөхийг бүх шатны комиссын дарга нарт даалгасугай.

5. Мал, тэжээвэр амьтад, хашаа худгийн тооллогын ажлыг аргачлал, маягт заавраар бүрэн хангаж ажиллахыг Төсөв, төрийн сангийн мэргэжилтэн (Н.Эрдэнэ-Очир)-т даалгасугай.

6. Мал, тэжээвэр амьтад, хашаа, худгийн тооллогын чанартай зохион байгуулах, төсөв, зардлыг олгогдсон эрх, үүргийнхээ дагуу шаардагдах зардлыг бүрэн санхүүжүүлж, гүйцэтгэлд хяналт тавьж ажиллахыг Тамгын газрын дарга (Б.Өнөрбаяр), Санхүү албаны дарга (Д.Азжаргал) нарт үүрэг болгосугай.

7. Мал, тэжээвэр амьтад, хашаа худгийн тооллого болон хяналтын зардалд тээвэр шатахууны зардлаас 2100,0 /Хоёр сая нэг зуун мянган/ төгрөгийг санхүүжүүлэхийг Тамгын газрын дарга (Б.Өнөрбаяр), Нягтлан бодогч (Б.Баттөр) нарт зөвшөөрсүгэй.

8. Мал, тэжээвэр амьтад, хашаа худгийн тооллогын үйл ажиллагааны талаар дэлгэрэнгүй илтгэх хуудас бичиж Удирдлагын багт танилцуулахыг мал, тэжээвэр амьтад, хашаа худгийн тооллогын ажлыг зохион байгуулах комиссын дарга (Б.Түмэнжаргал)-д үүрэг болгосугай.

ДАРГА  Б.САРАНЦЭЦЭГ

Сумын Засаг даргын... оны... дугаар  
сарын...-ны өдрийн... дугаар  
захирамжийн хавсралт



МАЛ, ТЭЖЭЭВЭР АМЬТАД, ХАШАА, ХУДГИЙН 2024 ОНЫ  
ЖИЛИЙН ЭЦСИЙН ТООЛЛОГЫН АЖЛЫГ ЗОХИОН БАЙГУУЛАХ  
КОМИССЫН БҮРЭЛДЭХҮҮН

д/д		Овог нэр	Албан тушаал
1		2	3
<b>Нам толгой 1 дүгээр багт</b>			
1	1 дүгээр чиглэл	Н.Ганжаргал	Багийн Засаг дарга
		Г.Бадамцэцэг	Нийгмийн даатгалын байцаагч
		Б.Буян-Аривжих	Нярав
		П.Пүрэвдорж	Жолооч
2	2 дугаар чиглэл	Ч.Цэдэвсүрэн	Багийн Засаг дарга
		Д.Мөнхзул	Хөдөлмөр эрхлэлт, халамжийн асуудал хариуцсан
		Т.Анударь	МЭТ-ийн тархвар зүйч
		Г.Мөнхтогтох	ЕБСургуулийн харуул
3	3 дугаар чиглэл	Б.Амгаланбаяр	ИТХ-ын төлөөлөгч
		Г.Батзаяа	Багийн эмч
		Ц.Одбаатар	Жолооч
		О.Уугандулам	Малчин
<b>Өлзийт өндөр 2 дугаар баг</b>			
4	1 дүгээр чиглэл	Д.Мөнхжаргал	ИТХ-ын дарга
		С.Жаргалсайхан	МЭТ-ийн дарга, улсын байцаагч
		Т.Алтаншагай	Улсын бүртгэгч
		Н.Эрдэнэмөнх	Жолооч
5	2 дугаар чиглэл	Ж.Должинсүрэн	Багийн Засаг дарга
		Г.Шийрэвсамбуу	Тусгай хамгаалалттай газрын байгаль хамгаалагч
		Ж.Сэргэлэнчимэг	Багийн эмч
		Б.Цогтбаатар	Жолооч
<b>Хөндлөн булаг 3 дугаар баг</b>			
6	1 дүгээр чиглэл	Д.Азжаргал	Санхүүгийн албаны дарга
		Ш.Ичинхорлоо	Татварын улсын байцаагч
		О.Мөнхжаргал	Биеийн тамирын арга зүйч
		Б.Батдорж	Жолооч
7	2 дугаар чиглэл	Б.Саранцэцэг	Сумын Засаг дарга
		Ц.Ганхуяг	Жолооч
		М.Алтанхуяг	Шүдний эмч
		Б.Нэмэхбаатар	ЕБСургуулийн харуул

8	3 дугаар чиглэл	Б.Гарьдсоном	Багийн Засаг дарга
		Ж.Сүхбаатар	Байгаль орчны улсын байцаагч
		Ж.Хаш-Эрдэнэ	Хүүхдийн эмч
		О.Мөнхбат	Жолооч
9	4 дүгээр чиглэл	А.Анхбаяр	Малчин
		С.Батжаргал	Хүүхдийн цэцэрлэгийн харуул
		Н.Төрмөнх	Жолооч

— оОо —